| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 249 | 249 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 65 | 65 | - | 100.0 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **315** | **315** | - | 100.0 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан (төгрөгөөр)**

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | хувь |
|---|---|---|---|---|---|
| II | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,330,409,400** | **1,032,009,400** | **298,400,000** | **77.6** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,330,409,400** | **1,032,009,400** | **298,400,000** | **77.6** |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 1,330,409,400 | 1,032,009,400 | 298,400,000 | 77.6 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 110,400,000.00 | 103,870,234.27 | 6,529,765.73 | 94.1 |
| 210302 | Түлш, халаалт | 820,009,400.00 | 628,139,165.73 | 191,870,234.27 | 76.6 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 400,000,000.00 | 300,000,000.00 | 100,000,000.00 | 75.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,330,409,400.00** | **1,032,009,400.00** | **298,400,000.00** | **77.6** |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 1,330,409,400.00 | 1,032,009,400.00 | 298,400,000.00 | 77.6 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,330,409,400.00 | 1,032,009,400.00 | 298,400,000.00 | 77.6 |

## Гурав. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**3.1** Аудитаар 11,480,155.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа[1]-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа:

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:**
- Санхүүгийн байдлын тайланд ажиллагчидтай холбогдсон авлагыг 700.4 мянган төгрөгөөр, эм боох материалыг 318.6 мянган төгрөгөөр,
- Машин тоног төхөөрөмжийн хуримтлагдсан элэгдлийг 1,757,299.0 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний зардлын өглөгийг 103.1 мянган төгрөгөөр, татварын өглөгийг 8,148.4 мянган төгрөгөөр,

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

- Дансны өглөгийг 30.1 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан,
- Санхүүгийн байдлын тайланд машин тоног төхөөрөмжийг 316.2 мянган төгрөгөөр, тайлант үеийн үр дүнг 1,764,039.2 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасан,
- Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 7,949,200.0 мянган төгрөгөөр дутуу,
- Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилтийг 7,949,200.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" заалтыг зөрчсөн байна.

Залруулагдаагүй нийт 156,182.6 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 156,182.6 мянган төгрөгийн 15 зөрчил[2] илэрсэнд 2 төлбөрийн акт, зөрчил арилгах, давтан гаргахгүй байх 6 албан шаардлага, 7 зөвлөмжийг хүргүүлсэн.

**5.2 Төлбөрийн акт**

1. Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас иргэдийг шагнахад 150.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", "Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

2. "Жи гоулд" ХХК-тай байгуулсан "Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн шинэ барилгын зориулалтын 2 өрөөг вакум мэс заслын өрөө болгон засварлан тоноглох, тоног төхөөрөмж нийлүүлэх" ажлын гэрээний хугацаа 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр дууссан байхад гэрээний дагуу алданги төлүүлээгүй. Аудит хийсэн өдрөөр тооцоход 6 хоногийн алданги 12,519.4 мянган төгрөгийг гүйцэтгэгч байгууллагаар төлүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6-т "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх", "Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн шинэ барилгын зориулалтын 2 өрөөг вакум мэс заслын өрөө болгон засварлан тоноглох, тоног төхөөрөмж нийлүүлэх" гэрээний 5.8-т "Гэрээний хугацаанд тоног төхөөрөмж болон ажлыг гүйцэтгээгүй, хэсэгчлэн нийлүүлээгүй тохиолдолд захиалагч талд нийлүүлээгүй үнийн дүнгээс хоног тутамд 0.5 хувийн алданги төлнө", 2.1-т "Гэрээний хугацаа: 2024 оны 11 дүгээр сарын 04-ний өдрөөс 2025 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийг хүртэл 90 /хоног/ -ийн хугацаатай байна" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

---

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Шийдвэрлэсэн нь: Алдангийг байгууллагын дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

**5.3 Албан шаардлага**

1. Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас өмнөх оны өр болох ахмадын хүлээн авалтын зардалд анхан шатны баримт дутуу 4,158.4 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах; Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", " Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-т "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас өмнөх оны өр төлж байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

2. Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлаас 4,800.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж,12,080.0 мянган төгрөгийн хагалгааны төлбөрийг тус тус олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах"; 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах"; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралт "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлын эдийн засгийн ангилал зөрчин гүйлгээ хийж байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

3. Урсгал засварын зардлаас 90,502.4 мянган төгрөгийн материалыг шууд худалдан авсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4-т "Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаа хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаагүй бол төсвөөс санхүүжилт гаргахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1-т "Захиалагч дараах үндэслэлээр аж ахуй эрхлэгчдийн дунд хэлэлцээ хийх замаар гэрээ шууд байгуулж болно" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Босго үнээс давсан төсөвт өртөг бүхий урсгал засварын зардалд худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

4. Жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хийсэн боловч тооцоо бодолт хангалтгүй, 55,773.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 20.2.6-т "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж,

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн тооллого зөрүүтэй хийгдсэн, тооцоо бодоогүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

5. Санхүүгийн тайланд 1-с дээш жилийн насжилттай он дамнасан 21,679.7 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага бүртгэлтэй нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.5-т "хуваарьт болон хугацаа хэтэрсэн өр төлбөрийг жилийн төсөвтөө бүрэн тусгаж өр төлбөр барагдуулах төлөвлөгөө, хуваарь баталж хэрэгжүүлэх" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд байгаа өмнөх онуудын авлагыг барагдуулахгүй байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

6. Туслах үйл ажиллагааны орлогоос 197,821.7 мянган төгрөгийг байгууллагын кассаар дамжуулан хураан авсан боловч орлогыг мөнгөн кассын журамд заасан хугацаанд дансанд тушаагаагүй, кассын тайлан зөрүүтэй, кассаас 9,707.0 мянган төгрөгийг донорын урамшуулал, онгоцны билет, кассын программын зардалд шууд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журам"-ын 2.6-т "Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана", 8.2-т "шалгалтаар зөрчил, дутагдал илэрвэл мөнгөн кассын нярав болон холбогдох албан тушаалтанд хуульд заасны дагуу хариуцлага тооцож, зөрчлийг барагдуулна" гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Кассын орлогыг журамд заасан хугацаанд дансанд төвлөрүүлэхгүй, бэлнээр шууд зарцуулж байгаа зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

## 5.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### *1. Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал*

*Илрүүлэлт:*

Нийгмийн даатгалд цалинг 20,848.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнаж 1,417.3 мянган төгрөгийн авлага үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т "Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлнө", 8 дугаар зүйлийн 8.2-т "Энэ хуулийн 4.4-т заасан байгууллага нь Төсвийн тухай хуулийн 26.3-т нийцүүлэн нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

гаргана.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;" Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 32 хуулийн 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх"-тэй нийцэхгүй байна.

*__Өгсөн зөвлөмж:__* Цалинг нийгмийн даатгалд зөрүүгүй тайлагнах, авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулах.

*__Илрүүлэлт:__*

Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 690,210.9 мянган төгрөг хасагдсан, орлогыг бүрэн төвлөрүүлээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах"; 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага дараах эрх, үүрэгтэй: 13.1.1.даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх"; 13.1.6-д "эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх даатгуулагчийн төлбөрийн тайлан тооцоо, холбогдох баримт бичгийг үнэн зөв, цаг хугацаанд нь гаргаж эрүүл мэндийн даатгалын байгууллагад ирүүлэх" заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*__Өгсөн зөвлөмж:__* Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг нэхэмжлэхдээ даатгуулагчийн төлбөрийн тооцоо, холбогдох мэдээллийг үнэн, зөв, цаг хугацаанд нь цахим системд бүртгэж, үйлчилгээний орлогыг бүрэн төвлөрүүлэн, байгууллагын үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлж, дотоод хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах.

*__Илрүүлэлт:__*
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд биет тооллого хийхэд 90.4 мянган төгрөгийн эмийн хугацаа дуусан байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах"; 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх" заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*__Өгсөн зөвлөмж:__* Эм эмнэлгийн хэрэгсэлд тооллого хийж, хугацаа дуусаж байгаа эмийн бүртгэлийг хөтөлж, хяналтыг сайжруулах арга хэмжээ авч ажиллах.

*__Илрүүлэлт:__*
Хөрөнгийн биет тооллогоор эвдэрсэн, цаашид ашиглах боломжгүй болсон 4 автомашин байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах"; 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т "Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно" заалттай тус тус нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*Өгсөн зөвлөмж:* Цаашид ашиглах боломжгүй болсон автомашиныг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2025 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Говь-Алтай аймаг дахь
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР

## Дөрөв. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдааны утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | тоо | Дүн | тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 | 14 |
| Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг | Санхүүгийн байдлын тайланд ажиллагчидтай холбогдсон авлагыг 700.4 мянган төгрөгөөр, эм боох материалыг 318.6 мянган төгрөгөөр, машин тоног төхөөрөмжийн хуримтлагдсан элэгдлийг 1,757,299.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлын өглөгийг 103.1 мянган төгрөгөөр, татварын өглөгийг 8,148.4 мянган төгрөгөөр, дансны өглөгийг 30.1 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан. | 1 | 1,766,599.6 | - | - | 1 | 1,766,599.6 | 1 | 1,766,599.6 | - | - | - | - |
| | Санхүүгийн байдлын тайланд машин тоног төхөөрөмжийг 316.2 мянган төгрөгөөр, тайлант үеийн үр дүнг 1,764,039.2 мянган төгрөгөөр тус тус илүү тайлагнасан. | 1 | 1,764,355.4 | - | - | 1 | 1,764,355.4 | 1 | 1,764,355.4 | - | - | - | - |
| | Үр дүнгийн тайланд үнэ төлбөргүй хүлээн авсан орлогыг 7,949,200.0 мянган төгрөгөөр дутуу, Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилтийг 7,949,200.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан. | 1 | 7,949,200.0 | - | - | 1 | 7,949,200.0 | 1 | 7,949,200.0 | - | - | - | - |
| **Дүн** | | **3** | **11,480,155.0** | **-** | **-** | **3** | **11,480,155.0** | **3** | **11,480,155.0** | | **-** | **-** | **-** |

Говь-Алтай аймаг дахь
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР

**4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл** **/мянган төгрөгөөр/**

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг | Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас иргэдийг шагнахад 150.0 мянган төгрөгийг зарцуулсан байна. | 1 | 150.00 | 1 | 150.00 | - | - | - | - | - | - |
| | "Жи гоулд" ХХК-тай байгуулсан "Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн шинэ барилгын зориулалтын 2 өрөөг вакум мэс заслын өрөө болгон засварлан тоноглох, тоног төхөөрөмж нийлүүлэх" ажлын гэрээний хугацаа 2025 оны 02 дугаар сарын 05-ны өдөр дууссан байхад гэрээний дагуу алданги төлүүлээгүй. Аудит хийсэн өдрөөр тооцоход 6 хоногийн алданги 12,519.4 мянган төгрөгийг гүйцэтгэгч байгууллагаар төлүүлээгүй байна. | 1 | 12,519.40 | 1 | 12,519.40 | - | - | - | - | - | - |
| | Нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас өмнөх оны өр болох ахмадын хүлээн авалтын зардалд анхан шатны баримт дутуу 4,158.4 мянган төгрөгийг зарцуулсан байна. | 1 | 4,158.40 | - | - | 1 | 4,158.40 | - | - | - | - |
| | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардлаас 4,800.0 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж,12,080.0 мянган төгрөгийн хагалгааны төлбөрийг тус тус олгосон. | 1 | 16,880.00 | - | - | 1 | 16,880.00 | - | - | - | - |
| | Урсгал засварын зардлаас 90,502.4 мянган төгрөгийн материалыг шууд худалдан авсан байна. | 1 | 90,502.40 | - | - | 1 | 90,502.40 | - | - | - | - |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг хийсэн боловч тооцоо бодолт хангалтгүй, 55,773.6 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. | 1 | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг | Санхүүгийн тайланд 1-с дээш жилийн насжилттай он дамнасан 21,679.7 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага бүртгэлтэй байна. | 1 | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| | Туслах үйл ажиллагааны орлогоос 197,821.7 мянган төгрөгийг байгууллагын кассаар дамжуулан хураан авсан боловч орлогыг мөнгөн кассын журамд заасан хугацаанд дансанд тушаагаагүй, кассын тайлан зөрүүтэй, кассаас 9,707.0 мянган төгрөгийг донорын урамшуулал, онгоцны билет, кассын программын зардалд шууд зарцуулсан байна. | 1 | 9,707.00 | - | - | 1 | 9,707.00 | - | - | - | - |
| | Нийгмийн даатгалд цалинг 20,848.1 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнаж 1,417.3 мянган төгрөгийн авлага үүсгэсэн. | 1 | 22,265.40 | - | - | - | - | 1 | 22,265.40 | - | - |
| | Эрүүл мэндийн даатгалын цахим системд илгээсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний мэдээлэл, нэхэмжилсэн дүнгээс чанарын болон төлбөрийн хяналтаар 690,210.9 мянган төгрөг хасагдсан байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэлд биет тооллого хийхэд 90.4 мянган төгрөгийн эмийн хугацаа дуусан байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг | Хөрөнгийн биет тооллогоор эвдэрсэн, цаашид ашиглах боломжгүй болсон 4 автомашин байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Өмнөх онд үүссэн өр төлбөрийг төсөвт тусгаагүйгээс шалтгаалсан он дамнасан өр төлбөрийг төлж тайлант онд 993,283.5 мянган төгрөгийн өр төлбөрийг нэмж үүсгэсэн байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| **Дүн** | | **13** | **156,182.60** | **2** | **12,669.40** | **6** | **121,247.80** | **5** | **22,265.4** | **-** | **-** |

**4.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал** **/мянган төгрөгөөр/**

| Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн товч утга | Нийт алдаа, зөрчлийн дүн | | Үүнээс: | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Тоо | Дүн | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | | | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 |
| Говь-Алтай аймгийн Нэгдсэн эмнэлэг | "Жи гоулд" ХХК-тай байгуулсан "Нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн шинэ барилгын зориулалтын 2 өрөөг вакум мэс заслын өрөө болгон засварлан тоноглох, тоног төхөөрөмж нийлүүлэх" ажлын гэрээний хугацаа дууссан, гэрээг дүгнээгүй, ажлын гүйцэтгэлийг хүлээж аваагүй, үе шатны ажлын хуваарийг батлаагүй, 70.0 хувийн санхүүжилтийг олгохдоо ажлын гүйцэтгэлийг үндэслээгүй байна. | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |
| | Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 22,007,335.2 мянган төгрөгийн 580 мэдээллээс, цалингаас бусад 5 саяас дээш орлого, зарлагын гүйлгээний 2,713,530.6 мянган төгрөгийн төгрөгийн 72 мэдээллийг мэдээлээгүй, бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа | 1 | - | - | - | - | - | 1 | - | - | - |

Говь-Алтай аймаг дахь ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | шийдвэр болох 152 мэдээллийг өөр цэсэд зөрүүлж мэдээлсэн, хэрэгжилт 89.7 хувьтай байна. | | | | | | | | | | |
| **Нийт** | | **2** | - | - | - | - | - | **2-** | - | - | - |

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

| № | Төсвийн захирагчийн ангилал | Байгууллага, нэгжийн тоо | | | | Санал дүгнэлтийн хэлбэр | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Аудитад хамрагдах | Үүнээс: Аудит хийсэн хэлбэр | | | | | | |
| | | | Санал дүгнэлт гаргасан | Түүвэрт хамруулсан | Аудит хийгээгүй | Өөрчлөлтгүй | Хязгаарлалттай | Сөрөг | Дүгнэлт өгөхөөс татгалзсан |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 7 | 8 | 9 | 10 |
| 1 | ТШЗ | | 1 | | | 1 | | | |
| | **НИЙТ** | | **1** | | | **1** | | | |

Говь-Алтай аймаг дахь
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР